

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2024/310/НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН АРГАЛАНТ СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2024 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Ц.Саранчимэг

Утас: 70272248 Цахим хаяг: saranchimegts@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: "Өлзийт экаунт аудит" ХХК

Гүйцэтгэх захирал Ч.Эрдэнэжав

Утас: 70130460 Цахим хаяг: auditulziit@gmail.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	8
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	10
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	11
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА.....	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	14
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	15
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
НД	Нийгмийн Даатгал
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ҮОМШӨ	Үйлдвэрлэл осол мэргэжлээс шалтгаалах өвчин
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100, Төв аймаг, Зуунмод сум
Утас: 70272582, Цахим шуудан: tuv@audit.gov.mn
Цахим хаяг: www.audit.mn

2024.02.25 № 4/2024

танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Аргалант сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Аргалант сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллагын үйл ажиллагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй бөгөөд бидний мэргэжлийн шийдлийн үнэлэмжээр, сонгон авсан горимуудад алдаа болон залилангийн улмаас санхүүгийн тайлан буруу илэрхийлэгдэх эрсдэлийн үнэлгээг багтаан санхүүгийн тайланд аудитын ажлыг гүйцэтгэхэд аудитад хамгийн ихээр нөлөө үзүүлэхүйц асуудлууд нь аудитын гол асуудлууд болдог. Аудитын явцад санхүүгийн тайланг бүхэлд нь хамруулан авч үзсэн бөгөөд аудитын агуулгын хүрээнд дүгнэлт гаргахад нөлөөлсөн асуудлууд байхгүй байна.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий ажил гүйлгээг дараах байдлаар тодорхойлж байна.

Тайлант 23,039.2 мянган төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, санхүүгийн тайланд бүртгэж, тайлагнасан байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл

019020216

үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	68,691,981.49	76,933,859.91
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	42,324,845.49	46,508,813.91
312	Банканд байгаа бэлэн мөнгө	42,324,845.49	46,508,813.91
3121	Төгрөг	42,342,845.49	46,508,813.91
31	Төрийн сангийн харилцах	42,324,845.49	46,508,813.91
33	АВЛАГА	28,270.00	-
33100	Ажиллагсадтай холбогдсон авлага	27,270.00	-
335	Бусад авлага	1,000.00	-
3351	Байгууллагаас авах авлага	1,000.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	26,338,866.00	30,425,046.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	75,000.00	
354	Хангамжийн материал	26,263,866.00	30,425,046.00
35410	Бичиг хэргийн материал	146,600.00	140,000.00
35420	Аж ахуйн материал	871,500.00	283,000.00
35460	Хүнсний материал	2,795,820.00	2,304,620.00
35470	Бусад хангамжийн материал	22,449,946.00	27,697,426.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	600,180,437.32	615,987,571.57
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	600,180,437.32	615,987,571.57
392	Биет хөрөнгө	595,920,437.32	611,727,571.57
39201	Барилга, байгууламж, орон сууц	595,074,251.22	595,074,251.22
39202	Хуримтлагдсан элэгдэл	(39,671,616.96)	(42,151,093.02)
39205	Машин тоног төхөөрөмж	26,929,020.00	27,961,020.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(2,525,906.69)	(2,919,416.36)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	17,445,790.00	37,243,316.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(8,296,506.95)	(10,354,306.32)
39214	Бусад үндсэн хөрөнгө	6,843,414.15	6,843,414.15
39215	Хуримтлагдсан элэгдэл	(1,190,886.45)	(1,282,493.10)
39217	Номын фонд	1,312,879.00	1,312,879.00
393	Биет бус хөрөнгө	4,260,000.00	4,260,000.00
39301	Программ хангамж	100,000.00	100,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(100,000.00)	(100,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	4,260,000.00	4,260,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	668,872,418.81	692,921,431.48
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	87,020.00	
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	87,020.00	
413	Өглөг	87,020.00	
4131	Ажилчидтай холбогдсон өглөг	27,270.00	
4136	Бусад өглөг	59,750.00	
41361	Байгууллагад төлөх өглөг	59,750.00	
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	668,785,398.81	692,921,431.48
51	Засгийн газрын хувь оролцоо	668,785,398.81	692,921,431.48
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	479,943,460.99	479,943,460.99
51101	Өмч:-төрийн	479,943,460.99	479,943,460.99
512	Хуримтлагдсан үр дүн	(6,111,480.36)	18,024,552.31
51210	Өмнөх үеийн үр дүн	(6,111,480.36)	(6,111,480.36)
51220	Тайлант үеийн үр дүн		24,136,032.67
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	194,953,418.18	194,953,418.18
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	668,872,418.81	692,921,431.48

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	979,971,104.47	340,460,906.80
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	638,120,304.47	23,039,206.00
120	Нийтлэг татварын бус орлого	638,120,304.47	23,039,206.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	611,467,753.47	20,829,526.00
1200017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө	611,467,753.47	20,829,526.00
1200018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал	26,652,551.00	2,209,680.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	105,747,700.00	56,741,500.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	236,103,100.00	260,680,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	236,103,100.00	260,680,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	52,747,500.00	56,741,500.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт/орон нутгийн төсөвт байгууллага	52,747,500.00	56,741,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	53,000,200.00	
131104	Дээд шатны төсвийн захирагчаас тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	53,000,200.00	
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	311,185,705.66	316,324,873.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	311,185,705.66	316,324,873.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	250,729,700.65	313,681,409.58
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	153,814,092.72	193,822,043.63
210101	Үндсэн цалин	117,329,752.25	149,010,806.45
210102	Нэмэгдэл	28,394,938.16	37,437,009.58
210103	Унаа хоолны хөнгөлөлт	44,000.00	214,000.00
210104	Урамшуулал	8,045,402.31	7,160,227.60
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,297,890.78	24,563,277.95
210201	Тэтгэврийн даатгал	13,145,108.01	16,834,318.55
210202	Тэтгэмжийн даатгал	1,540,306.81	1,934,959.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,232,245.52	1,457,967.85
210204	Ажилгүйдлийн даатгал	299,616.74	377,112.08
210205	Эрүүл мэндийн даатгал	3,080,613.70	3,868,919.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,301,796.00	55,283,836.25
210301	Гэрэл, цахилгаан	2,733,196.00	4,270,836.25
210302	Түлш, халаалт	32,313,600.00	50,688,000.00
210303	Цэвэр, бохир ус	255,000.00	325,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	783,600.00	
210401	Бичиг хэрэг	57,000.00	
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	48,100.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	678,500.00	
2105	Норматив зардал	20,622,875.00	25,140,660.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	45,500.00	
210502	Хоол, хүнс	20,412,575.00	25,410,660.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	164,800.00	

Төв аймгийн Аргалант сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
2107	Томилолт, зочны зардал	70,000.00	
210702	Дотоод албан томилолт	70,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	292,000.00	350,000.00
210806	Мэдээллийн технологийн үйлчилгээний хөлс	292,000.00	350,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	20,047,446.15	13,751,591.75
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,641,180.00	7,364,300.00
210902	Хичээл сургалт, үйлдвэрлэлийн дадлагын зардал	1,443,950.00	1,364,900.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	12,962,316.15	5,022,391.75
27	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,456,005.01	2,643,463.75
	Бусад урсгал шилжүүлэг	55,078,800.00	1,610,800.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	47,287,400.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагч	5,609,300.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,182,100.00	1,610,800.00
	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,377,205.01	1,032,663.75
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	668,785,398.81	24,136,032.67
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН		
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)		
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	668,785,398.81	24,136,032.67

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	341,850,800.00	317,421,700.00
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	341,850,800.00	317,421,700.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	236,103,100.00	260,680,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	236,103,100.00	260,680,200.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		
132001	Орон нутгийн төсвөөс санхүүжих	52,747,500.00	56,741,500.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	53,000,200.00	56,741,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагч	53,000,200.00	
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	297,850,954.51	313,237,731.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	297,850,954.51	313,237,731.58
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	237,393,949.50	310,594,267.83
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	153,814,092.72	193,908,095.11
210101	Үндсэн цалин	117,329,752.25	139,398,952.44
210102	Нэмэгдэл	28,394,938.16	46,879,431.57
210103	Унаа хоолны хөнгөлөлт	44,000.00	214,000.00
210104	Урамшуулал	8,045,402.31	7,415,711.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	19,297,890.78	24,476,226.47
210201	Тэтгэврийн даатгал	13,145,148.01	16,446,267.07
210202	Тэтгэмжийн даатгал	1,540,306.81	2,234,959.80
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,232,245.52	1,547,967.85
210204	Ажилгүйдлийн даатгал	299,576.74	377,112.08
210205	Эрүүл мэндийн даатгал	3,080,613.70	3,869,919.67
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	35,296,796.00	55,208,836.25
210301	Гэрэл, цахилгаан	2,733,196.00	4,270,836.25
210302	Түлш, халаалт	32,313,600.00	50,688,000.00
210303	Цэвэр, бохир ус	250,000.00	250,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	103,500.00	
210401	Бичиг хэрэг	103,500.00	
2105	Норматив зардал	19,837,590.00	24,919,460.00
210502	Хоол, хүнс	19,837,590.00	24,919,460.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00
210604	Урсгал засвар	500,000.00	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	592,000.00	495,000.00
210803	Мэдээлэл технологийн үйлчилгээ	592,000.00	495,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,952,080.00	11,086,650.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	6,202,180.00	9,599,750.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,749,900.00	1,486,900.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	60,457,005.01	2,643,463.75
2132	Бусад урсгал шилжүүлэг	55,079,800.00	1,610,800.00

Төв аймгийн Аргалант сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	47,287,400.00	
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагч	5,609,300.00	
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,183,100.00	1,610,800.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	43,999,845.49	4,183,968.42
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	1,675,000.00	
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	1,675,000.00	
2200	Дотоод эх үүсвэрээр	1,675,000.00	
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1,675,000.00	
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(1,675,000.00)	
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	42,324,845.49	
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	42,324,845.49	46,508,813.91
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	42,324,845.49	
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	42,324,845.49	46,508,813.91

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	479,943,460.99	194,953,418.18	(6,111,480.36)	668,785,398.81
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл				
Тайлант үеийн үр дүн				
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	479,943,460.99	194,953,418.18	(6,111,480.36)	668,785,98.81
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн	479,943,460.99	194,953,418.18	(6,111,480.36)	668,785,398.81
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт				
Тайлант үеийн үр дүн / цэвэр ашиг алдагдал/			24,136,032.67	24,136,032.67
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	479,943,460.99	194,953,418.18	18,024,552.31	692,921,431.48

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл		42,324,845.49	(42,324,845.49)	87.0%
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	359,054,140.00	312,205,067.80	46,849,072.17	87.0%
УРСГАЛ ЗАРДАЛ	359,054,140.00	312,205,067.80	46,849,072.17	87.0%
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	357,443,340.00	310,594,267.80	31,694,904.89	86.9%
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	225,603,000.00	193,908,095.10	31,694,904.89	86.0%
Үндсэн цалин	151,405,300.00	139,398,952.44	12,006,347.56	92.1%
Нэмэгдэл	69,353,400.00	46,879,431.57	22,473,968.43	67.6%
Унаа хоолны хөнгөлөлт		214,000.00	(214,000.00)	0
Урамшуулал	4,844,300.00	7,415,711.10	(2,571,411.10)	153%
Ажил олгогчоос НД-д төлөх шимтгэл	29,916,240.00	24,476,226.47	5,440,013.53	81.8%
Тэтгэврийн даатгал	20,179,440.00	16,446,267.07	3,733,172.93	81.5%
Тэтгэмжийн даатгал	2,433,800.00	2,234,959.80	198,840.20	91.8%
ҮОМШӨ-ний даатгал	1,947,600.00	1,547,967.85	399,632.15	79.5%
Ажилгүйдлийн даатгал	488,100.00	377,112.08	110,987.92	98.2%
Эрүүл мэндийн даатгал	4,867,300.00	3,869,919.67	997,380.33	79.5%
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	56,241,500.00	55,208,836.25	1,032,663.75	98.2%
Гэрэл, цахилгаан	5,303,500.00	4,270,836.25	1,032,663.75	80.5%
Түлш, халаалт	50,688,000.00	50,688,000.00	0	100.0%
Цэвэр, бохир ус	250,000.00	250,000.00	0	100.0%
Норматив зардал	33,599,900.00	24,919,460.00	8,680,440.00	74.2%
Хоол, хүнс	33,599,900.00	24,919,460.00	8,680,440.00	74.2%
Эд хогшил, урсгал засварын зардал	500,000.00	500,000.00	0	100.0%
Урсгал засвар	500,000.00	500,000.00	0	100.0%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж	495,600.00	495,000.00	600.00	99.9%
Мэдээллийн технологийн зардал	495,600.00	495,000.00	600.00	99.9%
Бараа үйлчилгээний бусад зардал	11,087,100.00	11,086,650.00	450.00	100.0%
Бараа үйлчилгээний бусад зардал	9,600,200.00	9,599,750.00	450.00	100.0%
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,486,900.00	1,486,900.00	450.00	100.0%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	1,610,800.00	1,610,800.00	0	100.0%
Бусад урсгал шилжүүлэг	1,610,800.00	1,610,800.00	0	100.0%
Нэг удаагийн мөнгөн тэтгэмж	1,610,800.00	1,610,800.00	0	100.0%

Төв аймгийн Аргалант сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	334,775,000.00	317,421,700.00	17,354,300.00	94.8%
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	278,034,500.00	260,680,200.00	17,354,300.00	93.8%
Улсын төсвөөс санхүүжих	278,034,500.00	260,680,200.00	17,354,300.00	93.8%
Орон нутгийн төсвөөс санхүүжих	56,741,500.00	56,741,500.00		100.0%
Орон нутгийн төсвөөс	56,741,500.00	56,741,500.00		100.0%
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		42,324,845.49	(42,324,845.49)	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		46,508,813.91	(46,508,813.91)	
АЖИЛЛАГСДЫН ТОО	34	34		
Удирдах ажилтан	2	2		
Гүйцэтгэх ажилтан	22	22		
Үйлчлэх ажилтан	10	10		

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Аргалант сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2022-2023 оны хичээлийн жилд “Хүүхдийн нийгэм, сэтгэл зүй, танин мэдэхүйн хөгжлийг дэмжих, боловсрол эзэмшихэд тэгш боломж бүрдүүлэх, сурагчдын сонирхолд тулгуурлан сургалт, үйл ажиллагааг чанар, үр дүнтэй зохион байгуулах, хамтран суралцах арга барилыг эзэмшүүлэх” зорилгыг дэвшүүлэн ажилласан байна.

Монгол Улсын Бага, дунд боловсролын тухай хуульд бага, суурь, бүрэн дунд боловсролын зорилгыг:

- Бага боловсрол: Эх хэлний суурь чадамжтай, бүтээлч, сурах арга барилтай монгол хүүхэд төлөвшүүлэх;
- Суурь боловсрол: Амьдрах ухаан, шинжлэх ухааны суурь мэдлэг, чадвар эзэмшсэн, бие даан бүтээлчээр суралцах чадамжтай иргэн төлөвшүүлэх;
- Бүрэн дунд боловсролын зорилго нь мэдээлэл боловсруулах, шийдвэр гаргах, суралцах чадвар бүхий ирээдүйд эзэмших мэргэжлийн ерөнхий суурь чадамжтай иргэн төлөвшүүлэх гэж тодорхойлсон.

Төв аймгийн Аргалант сумын Хүүхдийн цэцэрлэг нь гүйцэтгэлийн төлөвлөгөөг 5 зорилт, хэрэгжүүлэх 22 арга хэмжээтэй баталснаас нийт 95.5 %-тай дүгнэгдсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага үйл ажиллагаандаа Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Боловсролын тухай хууль, Сургуулийн өмнөх боловсролын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Тухайлбал: Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна. Тухайлбал:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль
- Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүү хяналт, дотоод аудитын албанаас хяналт, шалгалтын ажил хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Аргалант сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын 2021 оны 1 дүгээр сарын 26-ны өдрийн Боловсрол, шинжлэх ухааны сайдын А/22 тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба энэхүү баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаатай нийцэж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Аргалант сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 24,049.0 мянган төгрөгөөр буюу 3.6 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	42,324.8	46,508.8	4,184.0
Авлага	28.3		(28.3)
Бараа материал	26,338.9	30,425.0	4,086.1
Үндсэн хөрөнгө	600,180.4	615,987.6	15,807.2
Нийт хөрөнгө	668,872.4	692,921.4	24,049.0
Өр төлбөр	87.0		(87.00)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	668,872.4	692,921.4	24,136.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	668,872.4	692,921.4	24,049.0

Дээрх хүснэгтээс харахад: Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 4,184.0 мянган төгрөгөөр өссөн нь жилийн эцэст зарцуулаагүй үлдэгдлийг улсын төсөвт төвлөрүүлээгүйгээс шалтгаалсан байна.

Бараа материал дансны үлдэгдэл 4,086.2 мянган төгрөгөөр өссөн нь 2,209.6 мянган төгрөгийн бараа материалыг үнэ төлбөргүй хүлээн авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө данс 2023 онд машин тоног төхөөрөмж 1,032.0 мянган төгрөг, тавилга эд хогшил 19,797.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна. Энэ нь тайлант онд улсын төсвийн хөрөнгөөр 1,032.0 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмж, 430.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил худалдан авч, үнэ төлбөргүй хүлээн авсан 19,367.5 мянган төгрөгийн үндсэн хөрөнгөөр нэмэгдсэнтэй холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 692,921.4 мянган төгрөг болж 24,136.0 төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвийн санхүүжилтээр 239,870.1 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 56,741.5 мянган төгрөг, нийт 296,611.6 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Аргалант сумын Хүүхдийн цэцэрлэг нь дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 38,164.4 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 2023 оны урсгал зардлын төсвийг 334,776.0 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 334,776.0 мянган төгрөгөөс 4 удаа тодотгол хийж 312,205.0 мянган төгрөгийн санхүүжилтийг олгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 317,421.7 мянган төгрөгийн санхүүжилтийг авч, оны эцэст зарцуулаагүй үлдэгдэл 46,508.8 төгрөг байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 256,496,6 мянган төгрөг буюу 98.2 хувьтай байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
Д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	71802-Сургуулийн өмнөх боловсрол				
1.1	81605-Эрүүл мэндийг дэмжих	743.4	743.0	0.4	99%
1.2	81807-Цэцэрлэгийн хүүхдийн хоол	32,411.9	24,919.4	7,492.4	76%
1.3	81816-Хүүхдэд ээлтэй сургалтын орчин	2,202.4	2,202.4	0	100%
1.4	81823-Боловсролын байгууллагын багш ажилчид мэргэжил дээшлүүлэх	743.4	743.4	0	100%
1.5	81832-Нүүдлийн бүлэгт хамруулах	8,532.0	2,810.4	5,721.5	32%
1.6	81834-Боловсрол стандарт сургалт	136,808.8	119,063.3	17,744.7	87%
1.7	81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа	84,776.8	69,227.1	15,549.6	81%
	Дүн	266,218.0	219,709.2	46,508.7	82%
Орон нутгийн төсвөөс					
1	Байр ашиглалттай холбоотой зардал	56,241.5	55,208.8	1,032.7	98.2%
2	Эд хогшил худалдан авах	500.0	500.0		100%
	Дүн	56,741.5	55,708.8	1,032.7	99.0%
	Нийт дүн	322,959.5	275,418.0	47,541.4	

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.4 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Төв аймгийн Аргалант сумын Хүүхдийн цэцэрлэг нь тайлант онд худалдан авах ажиллагааны төлөвлөгөөгөөр нийт 45,682.0 мянган төгрөгийн бараа, ажил үйлчилгээ худалдан авахаар төлөвлөсөн. Үүнд: Хүүхдийн хоол хүнс- 33,599.9 мянган төгрөгийн нээлттэй тендер шалгаруулахаар, 12,082.7 мянган төгрөгийн бараа үйлчилгээний зардал, бичиг хэрэг, хичээл үйлдвэрлэл, төлбөр хураамжийн зардлуудыг шууд худалдан авалтаар гэрээ байгуулахаар тус бүр төлөвлөсөн. Гүйцэтгэлээр 37,001.7 мянган төгрөгийн худалдан авалтыг төлөвлөгөөний дагуу худалдан авах ажиллагааны зохих журмаар хийсэн байна. Худалдан авалтын дүн буурсан нь цэцэрлэгийн хүүхдийн тоо багассантай холбоотой 8,680.4 төгрөгийн хоол хүнсийг зарцуулаагүй болно.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Төв аймгийн Аргалант сумын Хүүхдийн цэцэрлэг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахаар нягтлан бодох бүртгэлтэй холбоотойгоор мөнгөн гүйлгээний тайлангаарх цалингийн зардлыг үнэн зөв илэрхийлэх, эцэг, эхчүүд болон иргэд, байгууллагаас авсан хандив тусламжаар өгсөн үндсэн хөрөнгө, бараа материалыг авахдаа “Сургууль цэцэрлэг хөгжүүлэх сан”-ийн үлгэрчилсэн дүрмийг хэрэгжүүлэн ажиллахтай холбоотой өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг “Өлзийт экаунт аудит” ХХК-ний Аудитор Ч.Эрдэнэжав гүйцэтгэж, чанарын хяналтыг Чанарын хяналтын менежер Ц.Бямбажав нар хэрэгжүүлж, дараагийн хяналтыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын Аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Аргалант сумын Хүүхдийн цэцэрлэг нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг “Өлзийт экаунт аудит” ХХК-д аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 24 -ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Аргалант сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Аргалант сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлага 311,185.7 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 4,667.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 3,500.8 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тус цэцэрлэг нь тайлант онд Төрийн хэмнэлтийн тухай хуулиар хориглосон зардлууд гараагүй, өглөг үүсгээгүй, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй зарцуулан ажилласан байна.

Судалгааны үр дүн, нөхцөл байдлын талаар бичих

Төв аймгийн Аргалант сумын Хүүхдийн цэцэрлэг бүртгэлд байгаа үндсэн хөрөнгө болон цалин хөлс, урамшуулал, байр ашиглалт, эрүүл мэндийг дэмжих, хүүхдийн хоол, багшийн мэргэжил дээшлүүлэх, цахим хэрэглээ, хэрэгжиж буй төсөл арга хэмжээтэй холбоотой 8 судалгааг ирүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Аргалант сумын Хүүхдийн цэцэрлэгийн шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад нийт мэдээлбэл зохих 159 мэдээллээс 4 мэдээллийг хугацаа хоцроож, 150 мэдээллийг хуулийн хугацаанд, 5 мэдээллийн мэдээлэх хугацаа болоогүй байна

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Аргалант сумын Хүүхдийн цэцэрлэгийн эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2022 оны санхүүгийн тайлангийн аудитаар 3 зөвлөмж, 3 албан шаардлага өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2023 оны 06 дугаар сарын 14-ны өдрийн 15 тоот албан тоотоор хүргүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	3	97,370.6	3	97,370.6	100%
Зөвлөмж	3	1,175.0	3	1,175.0	100%
Нийт дүн	6	98,545.6	6	98,545.6	100%

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн албан шаардлага, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Аргалант сумын Хүүхдийн цэцэрлэгт дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

5.1 Залруулаагүй алдаа

Аудитаар нийт 412.1 мянган төгрөгийн зөрчил илэрснээс 2 зөвлөмж хүргүүллээ.

Зөвлөмж

1. Хандив тусламжийн орлоготой холбоотой асуудал

Илрүүлэлт: Тайлант онд эцэг, эхчүүд болон иргэд, байгууллагаас авсан хандив тусламжаар өгсөн үндсэн хөрөнгө, бараа материалыг авахдаа "Сургууль цэцэрлэг хөгжүүлэх сан"-ийн үлгэрчилсэн дүрмийг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Энэ нь Боловсролын тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1 Боловсролын санхүүжилт нь улс, орон нутгийн төсөв, сургалтын төлбөр, дотоод, гадаадын аж ахуйн нэгж, байгууллагаас дүрэмд заасан үйл ажиллагаанд зориулсан хандив, тусламж, зээл, боловсролын байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлого зэрэг нийтлэг эх үүсвэрээс бүрдэнэ; Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд, Сангийн сайдын хамтарсан 2008 оны 56/64 дугаар тушаалын 1.1 Өмчийн хэлбэр харгалзахгүй их, дээд сургууль, коллеж, мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, ерөнхий боловсролын сургууль /цаашид сургууль гэх/, цэцэрлэгт дотоод, гадаадын хуулийн этгээд, иргэн, эцэг эх, асран хамгаалагч, сайн дурын байгууллагаас /цаашид хандивлагч болон тусламж үзүүлэгч гэх/ санаачлан сайн дурын үндсэн дээр тухайн байгууллагын дүрэмд заасан үйл ажиллагаанд зориулан өгсөн хандив, буцалтгүй тусламжийн орлогыг "Сургууль, цэцэрлэг хөгжүүлэх сан"-д бүртгэж авах, зарцуулах, хяналт тавих, мэдээ тайланд тусгах харилцааг энэхүү дүрмээр зохицуулна" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Холбогдох заавар журмын дагуу тайлант хугацаанд хандив тусламжийн хөрөнгийг сан байгуулан зарцуулалтыг хянаж, мэдээ тайланг бэлтгэж хэвших.

2. Цалингийн зардалтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Цалингийн хүснэгтээр цалингийн зардал мөнгөн гүйлгээний тайлангаарх нийт цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын дүнгээс 412.1 төгрөгөөр зөрүүтэй илэрхийлэгдсэн байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйл "Аж ахуйн нэгж, байгууллага нягтлан бодох бүртгэлийн дараах зарчмыг баримтална 5.1.3-т жинхэнэ хэрэгжилтийн; 5.1.4-т үнэн зөв байх" зарчмыг хэрэгжүүлэн ажиллах" гэж заасныг болон санхүүгийн тайлангийн "тохиолдсон байх", "нийцсэн бөгөөд зохистой байх" гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Хууль тогтоомжийг хэрэгжүүлэн тооцоологдсон цалин хөлсийг холбогдох тайлангуудтай хянаж тайлагнан хэвших

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Цалин хөлсний бүртгэл зөрүүтэй	1	412.1					1	412.1				
Хандив, тусламжаарх үндсэн хөрөнгө, бараа материалыг авахдаа сан бүрдүүлээгүй	1	-					1	-				
Дүн	2	-					2	-				